



## ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, ажилд дадлагажуулан зуучлах цогц үйлчилгээг туршин нэвтрүүлэх болон аж ахуй эрхлэх бүтээлч, шинэлэг санал, санаачлагыг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

### Хоёр. Хамрах хүрээ

Хөтөлбөрт дараах иргэн, боловсролын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна.

- 2.1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн, 15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд;
- 2.2. Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөөд 3 хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагагүй ажил хайж буй залуучууд;
- 2.3. Их, дээд сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага;
- 2.4. Аж ахуйн нэгж, байгууллагууд.

### Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хөтөлбөрийн хүрээнд дараах үндсэн арга хэмжээг зохион байгуулна.
- 3.1. Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх
    - 3.1.1. Ажил хайгчийн хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийх;
    - 3.1.2. Ажил хайгчид хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулахад туслах;
    - 3.1.3. Ажил хайгч залуучуудын хамтын ажиллагааг дэмжих;
    - 3.1.4. Ажил олгогчид тохирох ажилтныг ажил хайгчид тохирох ажил зуучлах арга хэмжээг ганцаарчилсан ба бүлгийн зохион байгуулалттай хэлбэрээр хэрэгжүүлэх;
    - 3.1.5. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн тухай мэдээллээр хангах.
  - 3.2. Залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх
    - 3.2.1. Ажил хайгч залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх.
  - 3.3. Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох
  - 3.4. Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах

*Хөтөлбөрийг дараах байгууллага, албан тушаалтан удирдлага, арга зүй, зохицуулалт, зохион байгуулалтаар хангаж ажиллана.*

- 3.5. Хөтөлбөрийг удирдлага, арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, зохион байгуулалтаар хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд хангаж ажиллана.
- 3.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна.
- 3.7. Хөтөлбөрийн тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална. Тайлангийн маягтад хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрт хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэж батлана.

### **Дөрөв. Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх**

Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс энэ хөтөлбөрийн 2.1, 2.2 дахь хэсэгт заасан иргэний онцлог хэрэгцээг тодорхойлж, дараах нийтлэг үйлчилгээнд хамруулна.

- 4.1. Ажил хайгчийн хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийх.
- 4.1.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв ажил хайгч залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг зохих аргачлалын дагуу хийнэ.
- 4.1.2. Ажил хайгч залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын хувьд боломжтой, дунд зэрэг, боломж багатай гэж гурав ангилана.
- 4.2. Ажил хайгчид хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг боловсруулахад нь туслах.
- 4.2.1. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэн орох чадварын хувьд боломжтой гэсэн үнэлгээ авсан залуучуудыг тохирох ажилд зуучилна. Тохирох ажил олдохгүй бол ажил хайгчид хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлнэ.
- 4.2.2. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын хувьд дунд зэрэг, боломж багатай гэсэн үнэлгээ бүхий ажил хайгч залуучуудтай хамтран хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг боловсруулахад нь тусалж, тухайн хүний ур чадвар, хэрэгцээнд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд хамруулан дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.3. Ажил хайгч залуучуудын хамтын ажиллагааг дэмжих.



- 4.3.1. Ажил хайгч залуучуудын хамтын ажиллагааг дэмжих үйлчилгээг бүлгээр зохион байгуулах бөгөөд бүлгийг ажил хайгч 15-20 залуугаас бүрдүүлэн дараах багц арга хэмжээг зохион байгуулна.
- 4.3.1.1. Өөрийгөө танин мэдэх, үнэлэх, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэн орох, ажил хайх чадвар эзэмших, ажил хайх гарцааны бизнес эхлэх гэсэн үе шат бүхий сургалтад хамрагдах;
- 4.3.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагад танилцах аялал зохион байгуулах;
- 4.3.1.3. Дундын зориулалттай байраар үйлчлэх;
- 4.3.1.4. Тохирох ажилд ганцаарчилсан болон бүлгийн зохион байгуулалттайгаар зуучлах.
- 4.4. Ажил олгогчид тохирох ажилтныг ажил хайгчид тохирох ажил зуучлах арга хэмжээг ганцаарчилсан ба бүлгийн зохион байгуулалттай хэлбэрээр хэрэгжүүлэх
- 4.4.1. Дараах ажил олгогч, ажил хайгч эсвэл ажилтанд ганцаарчилсан хэлбэрээр зуучилна.
- 4.4.1.1. Ажлын байрны захиалгыг маягтын дагуу ирүүлсэн ажил олгогч;
- 4.4.1.2. Өндөр ур чадвартай, мэргэшсэн ажилтан хайж буй ажил олгогч;
- 4.4.1.3. Тохирох өөр ажил буюу амьдарч буй газарт ойр ажил хайж буй ажилтан;
- 4.4.1.4. Ганцаарчилсан хэлбэрээр үйлчилгээ авахаар хүсэлт гаргасан ажил олгогч, ажил хайгч.
- 4.4.2. Бүлгийн зохион байгуулалтыг нэг буюу хэд хэдэн ажил олгогчид тодорхой бүлэг ажил хайгчдыг зуучлах төрөл бүрийн (хөдөлмөрийн яармаг, цагийн ажлын өдөрлөг зохион байгуулах, ажил товлох шуурхай ярилцлага хийх, урьдчилан тохирсон аж ахуйн нэгж, байгууллагаар тойрон явж ярилцлага хийх, эрэлт ихтэй мэргэжлээр сургууль төгсөгчдийг ажилд зуучлах гэх мэт) аргаар хийнэ.
- 4.4.3. Дараах ажил олгогч, ажил хайгч нарт бүлгийн зохион байгуулалттай хэлбэрээр зуучилна.
- 4.4.3.1. Бүлэг ажил хайгчдаас сонголт хийх хүсэлтэй ажил олгогч буюу хэд хэдэн ажил олгогч;
- 4.4.3.2. Тухайн үед эрэлт хэрэгцээтэй болсон мэргэжлүүдээр ажиллах хүч нэмж авах шаардлагатай байгаа ажил олгогч;
- 4.4.3.3. Улирлын болон цагийн ажилд ажилтан авах хүсэлтэй ажил олгогчид;
- 4.4.3.4. Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид;
- 4.4.3.5. Бүлгийн зохион байгуулалттай хэлбэрээр үйлчилгээ авч буй ажил хайгчид.
- 4.5. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн тухай мэдээллээр хангах хүрээнд дараах арга хэмжээ хэрэгжүүлэх.
- 4.5.1. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг 2 жилд нэг удаа аргачлалын дагуу хийнэ.



- 4.5.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсүүд орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн үр дүнгийн судалгааг сэдэвчилсэн байдлаар зах зээлийн нөхцөл байдал, ажил олгогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг үндэслэн хийнэ.
- 4.5.3. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, судалгааг аймаг, нийслэл, дүүргийн судалгааны баг дангаараа эсвэл хөдөлмөрийн зах зээлийн судалгаа эрхэлдэг байгууллагуудтай төслийн дэмжлэгтэйгээр хамтран гүйцэтгэж болно. Судалгааг хамтран гүйцэтгэх тохиолдолд судалгаа хийх багтгэл хангах, өгөгдөл цуглуулах, өгөгдлийн тоо, чанарт хяналт тавих, өгөгдөл оруулах зэрэг ажлыг аймаг, нийслэл, дүүргийн судалгааны багаареэ гүйцэтгэнэ.
- 4.5.4. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн судалгааны зардлыг орон нутгийн төсвөөс болон олон улсын хөтөлбөр, төслөөс санхүүжүүлнэ.



**Тав. Залуучуудад ажлын дадал, туршлага  
эзэмшүүлэх үйлчилгээг туршилтаар  
хэрэгжүүлэх**

Сонгогсон<sup>1</sup> аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв хөтөлбөрийн 2.2 дахь бүлэгт заасан иргэнийг ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээнд хамруулна.

- 5.1. Ажил хайгч залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх
- 5.1.1. Ажил хайгч залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх (Цаашид “Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ” гэх) үзүүлэх хүсэлтэй ажил олгогчдыг бүртгэх, гэрээ байгуулах үйлчилгээ үзүүлнэ.
- 5.1.2. Ажил хайгч залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ танилцуулах уулзалтыг ажил олгогчтой ганцаарчлан болон бүлгээр зохион байгуулж, “Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай хүсэлт гаргах өргөдлийн маяг”<sup>2</sup> болон “Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах тухай гэрээ”-ний загварыг<sup>3</sup> санал болгоно.
- 5.1.3. Уулзалтуудын дараа ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх хүсэлт бүхий ажил олгогчдын урьдчилсан жагсаалт гаргаж, хүсэлтийг албан бичгээр авна.
- 5.1.4. Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх ажил олгогчдыг сонгох ажлыг хэсгийг байгуулж ажиллана. Ажил олгогчийг сонгоход ажлын дадал, туршлага эзэмшүүлэх халамжлагч ажилтан (Цаашид “Дадал, туршлага эзэмшүүлэгч” гэх) байгаа эсэх, Ажлын дадал,

<sup>1</sup> 2021 онд туршилтаар 3 аймагт Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамртан хэрэгжүүлнэ.

<sup>2</sup> Өргөдлийн маягтын загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

<sup>3</sup> Гэрээний загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.



- туршлага эзэмшүүлэх үйлчилгээний үргэлжлэх хугацаа, дадал, туршлага эзэмшүүлсний дараа тухайн ажлын байранд ажил хайгч залууг ажиллуулах боломжтой эсэх, мөн хөдөлмөрийн гэрээ байгуулж, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлдөг эсэхийг нь харгалzan үзнэ.
- 5.1.5. Ажлын хэсгийн дүгнэлт болон бүртгэлтэй ажил хайгч залуучууд болон тусгайлан бүртгэсэн залуучуудын эрэлт, хэрэгцээг үндэслэн “Ажлын хэдэлмөр эрхлэлтийн тусгайлан хот” дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах тухай гэрээ”-г тухайн ажил олгогчтой байгуулна.
- 5.1.6. Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээгээр дэмжилгэгч авах хүсэлтэй ажил хайгч залуучуудыг бүртгэх, гэрээ байгуулах үйлчилгээ үзүүлнэ.
- 5.1.7. Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээний талаар тэдгээрийн төгсөгчдөд мэдээлэл өгөхийн зэрэгцээ нийгмийн түншлэлийн хүрээнд хамтран ажилладаг ажил олгогчдынх нь талаар мэдээлэл авна.
- 5.1.8. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, Хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгаа ажил хайгч залуучуудын мэргэжил, мэргэшил, ажилласан жил, туршлагын талаар тусгайлан судалгаа хийж зохих мэргэжил эзэмшсэн залуучуудад ажил олгогчийн хүсэлтийн талаар мэдээлнэ.
- 5.1.9. Шаардлагатай тохиолдолд зарим ажил олгогчдын хүсэлтэд дурдсан мэргэжлээр үйлчилгээ үзүүлэх тухай зарыг их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, коллеж төгсөөд З хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагагүй, ажил хайгч залуучуудад хандан гаргаж, ажил хайгч залуучуудыг өргөдлийнх нь дагуу бүртгэнэ. Хүсэлтийн хамт иргэний үнэмлэх, боловсролын диплом, гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.
- 5.1.10. Хүсэлт гаргасан ажил хайгч залуучууд ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргасан ажил олгогчдын хүсэлттэй танилцах, ярилцлагад орох, ажлын дадал, туршлага эзэмшүүлэх төлөвлөгөөтэй танилцаж, харилцан шийдвэр гаргана.
- 5.1.11. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай хүсэлтийг дээр дурдсанаар гаргасан ажил олгогч болон сонирхогч ажил хайгч залуу (Цаашид “Дадал, туршлага эзэмшигч” гэх)-тай гурвалсан гэрээ<sup>4</sup> байгуулна.
- 5.2. Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх ажил олгогч нь дээр дурдсан гурвалсан гэрээнд тусгаснаар дараах зардлыг хариуцна.
- 5.2.1. Дадал, туршлага эзэмшигч ажлын байрыг бэлтгэх зардал;
- 5.2.2. Дадал, туршлага эзэмшигчтэй хөдөлмөрийн хугацаатай гэрээ байгуулснаар тухайн мэргэжлийн ажилтны цалингийн доод хэмжээтэй тэнцэх хэмжээний үндсэн цалин олгох;

<sup>4</sup> Гурвалсан гэрээний загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

- 5.2.3. Дадал, туршлага эзэмшигчийн хүн амын орлогын татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх;
- 5.2.4. Дадал, туршлага эзэмшигчид ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын олговор олгох;
- 5.2.5. Дадал, туршлага эзэмшигчийн хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан тохиолдолд ажлын эхний 5 өдрийн тэтгэмж олгох;
- 5.2.6. Дадал, туршлага эзэмшүүлэгч сарын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгох, нэмэгдэл хөлсөнд ногдох хүн амын орлогын татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх.
- 5.3. Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээнд ажилгүй дараах залуучуудыг хамруулж болно.
- 5.3.1. Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, коллеж төгсөөд З хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагагүй;
- 5.3.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс зохион байгуулдаг хөдөлмөрт бэлтгэх буюу давтан сургах сургалтад хамрагдсан;
- 5.3.3. Боловсролын үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшил дээшлүүлэх боловсролын хөтөлбөрт хамрагдаж мэргэжил эзэмшсэн, давтан суралцсан буюу мэргэшлээ дээшлүүлсэн;
- 5.3.4. Гурав хүртэл настай хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэл насны хүүхэд асрах чөлөө авч удаан хугацаагаар ажил эрхлээгүй.



#### **Зургаа. Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох**

*Шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал, санаачлага гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-Ап” залуу, залуучуудын багийг дараах байдлаар шалгаруулж, эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгоно.*

- 6.1. Аймагт аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал, санаачлага гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-Ап” залуу, эсхүл залуучуудын багийг шалгаруулж, 10.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгийг олгоно.
- 6.1.1. Санхүүгийн дэмжлэгийг аймагт 1 шилдэг “Старт-Ап”-т, дүүрэгт 2 шилдэг “Старт-Ап”-т олгоно.
- 6.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар аймагт эхний 3 байр, дүүрэгт эхний 5 байрт шалгарсан “Старт-Ап” залуу, залуучуудын багийг хүсэлтийн дагуу шалгаруулалтад оролцуулж, улсын хэмжээний шилдэг 3 “Старт-Ап”-ийг шалгаруулна.
- 6.2.1. Улсын хэмжээний шилдэг “Старт-Ап”-уудад 20.0 сая, 17.0 сая, 13.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгийг олгоно.

- 6.3. Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, бүлгээр ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах, шалгарсан “Старт-Ап”-ын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг зохион байгуулах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагатай гэрээний үндсэн дээр зохион байгуулна.
- 6.4. Арга хэмжээг хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

**Долоо. Оюутан, залуучуудыг цагийн  
ажилд зуучлах**



Улаанбаатар хотод оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучлах арга хэмжээг Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, аймагт аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журам”-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

**Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт,  
хүрэх үр дүн**

- 8.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:
  - 8.1.1. Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ;
  - 8.1.2. Залуучуудад ажлын дадлага, туршилага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, хөрөнгийн хэмжээ;
  - 8.1.3. Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, дэд арга хэмжээ тус бүрээр;
  - 8.1.4. Цагийн ажилд зуучлах арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ.
- 8.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн:
  - 8.2.1. Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна;
  - 8.2.2. Ажлын дадлага, туршилага эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан залуучуудын 40-оос доошгүй хувь нь ажлын байртай болсон байна;
  - 8.2.3. Залуучуудын гарааны бизнес, санхүүгийн дэмжлэгийн үр ашиг дээшилсэн байна;
  - 8.2.4. Цагийн ажилд зуучлагдсан оюутан, суралцагчид түр ажлын байраар хангагдсан байна;
  - 8.2.5. Залуучуудын бизнес, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.

—ooOoo—